350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	49,987,062.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98,852,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	99,869,939.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	117,604,301.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	96.00	96.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00



62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	45.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00
620004	Гэрээт ажилтан	7.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	45.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	26.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348,690,056.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,690,056.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,904,877.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,342,817.00
210302	Түлш, халаалт	187,342,817.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,475,875.00
210402	Тээвэр, шатахуун	4,475,875.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	153,086,185.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,086,185.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,785,179.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,785,179.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,785,179.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	348,690,056.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,690,056.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	85,948,220.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,525,983.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,269,353.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,946,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дуут сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн төр иргэдийн гүүр нь байж сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, хамтач, хөдөлмөрч, соёлч, хууль ёсыг дээдэлсэн үйл ажиллагааг эрхэмлэн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж шударга ёсыг дээдлэн сум орон нутгаа хөгжүүлнэ ” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих

- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11/13 -р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ын хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийн жагсаалт гаргаж холбогдох хууль журамд нийцүүлэн шийдвэрлэж ажлыг 88 хувьтай дүгнүүлсэн байна.

Дуут сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,455.2 сая төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	122.7	144.3	21.6	1.2
Авлага	199.2	107.4	-91.8	0.5
Урьдчилгаа	14.1	11.5	-2.6	0.8
Бараа материал	68.9	36.0	-32.9	0.5
Үндсэн хөрөнгө	5211.1	1581.6	-3629.5	0.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5620.5	1880.8	-3739	0.4
Богино хугацаат өр төлбөр	15.8	10.0	-5.1	1.3
Цэвэр хөрөнгө, өмч	5604.7	1870.8	-3733.9	0.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7309.4	2854.2	4,455.2	0.4

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 122.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 144.3 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Энэ нь МАА-н татвар давж орсонтой холбоотой байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 107.4 сая төгрөг болж, өмнөх оноос 91.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	

Ажиллагсадтай холбогдсон авлага	7.2	1.5	(5.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	21.0	0.00	(21.0)
Татаас, санхүүжилтийн авлага	11.5	0.00	(11.5)
Хувь хүмүүст олгосон зээл	133.7	98.8	(34.9)
Байгууллагаас авах авлага	23.3	6.7	(16.6)
Хувь хүмүүсээс авах авлага	2.4	0.3	(2.1)
Дүн	199.1	107.4	(91.8)

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 91.8 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас нэмж зээл гаргаагүй 44.2 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулсан, Улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй 47.6 сая төгрөгийн авлага шилжиж барагдуулсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 11.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын сан	14.1	11.5	(2.6)
Дүн	14.1	11.5	(2.6)

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дуут сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2015 оноос малжуулах зээл олгож байсантай холбоотой 5 иргэний зээл барагдсан байна. Үлдэгдэл 7 иргэнтэй холбоотой өрийн асуудал шүүхийн шатанд хянагдаж байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 36,0 сая төгрөг болж 32.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Тусгай зориулалттай материал	0.00	0.00	0.00	0.0
Эм боох материал	5.5	0.00	-5.5	0.0
Хангамжийн материал	63.4	36.0	27.4	0.6
Бичиг хэргийн материал	0.2	0.00	0.2	1.0
Аж ахуйн материал	21.3	8.9	12.4	0.4
сэлбэг хэрэгсэл	0.5	0.0	0.5	1.0
Хүнсний материал	9.6	0.00	9.6	1.0

Бусад хангамжийн материал	31.9	27.2	-4.7	0.9
Нөөцийн бараа	4.6	0.0	-4.6	1.0
Нийт бараа материал	68.8	36.0	32.8	0.5

Тайлант хугацаанд буцаан олгох нөхцөлтэйгөөр хөрөнгөөр 10.0 сая, хандиваар 20.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, малын хөлийн татвараас 17.1 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 35.1 сая төгрөгийн материалыг зарцуулж, 29.4 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансаж шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6909.5 сая төгрөг байсан бол оны эцэст 1581.5 сая төгрөг болж 5328.0 сая төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй 38.0 сая төгрөгийн мал эмнэлгийн зориулалтай УАЗ-452 машин, бага оврын 3 трактор, 14.3 сая төгрөгийн өртөгтэй Зочид буудлын барилга байгууламжийг дуудлага худалдаагаар борлуулж данс бүртгэлээс хасаж, Төсөв, хандив, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын 148.5 сая төгрөгөөр худаг, мал угаалгын ванн, мэдээллийн самбар, алдрын танхим, хаяг гэрэлтүүлэг, БИТөв, туульсын өргөөний газруудыг орлогод авч, улсын төсвийн байгууллагуудын 4221.8 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж 382.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.8 сая, эцсийн үлдэгдэл 13.8 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлан хугацаанд 12 жилийн сургуулийн 4.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварт өрийг шилжүүлж, нэмэлт дансны 11,5 сая төгрөгийг олгосон ба аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэн, нэмэлт дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 3.7 сая төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2148,6 сая төгрөг байснаас оны эцэст 876.9 сая төгрөг болж 1271.7 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүдийн хөрөнгө системийн дээд байгууллагуудад шилжсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1213.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1213.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17 өдрийн 5/04 тоот тогтоолоор 1122.4 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны 8/02 тоот тогтоолоор улсын төсвийн байгууллагуудын гэрээт ажилтнуудын цалин хөлсийг харьяа газруудад төвлөрүүлсэнтэй холбоотой нийт 1019.3 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1019.3 сая төгрөгийн төсөв баталснаас 571.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 193,7 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 132.2 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 20.6 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлжээ.

Сумын татварын орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотойгоор аймгийн Засаг даргын А/821 тоот захирамжаар Дуут сумын санхүүгийн дэмжлэгт 13.5 сая төгрөгийг нэмэлт зохицуулалт хийж авсан байна.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

сая төгрөгөөр

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын болон татварын бус орлого	217.5	194.3
Татварын орлого	215.9	189.8
Татварын бус орлого	1.6	4.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	703.9	703.9
Орон нутгийн төсвөөс	571.7	571.7
Орон нутгийн хөгжлийн сан	132.2	132.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	99.4	20.5
Туслах үйл ажиллагааны орлогоос	0.6	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98.0	20.5
Засаг даргын захирамж		13.5
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	1019.3	932.3

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 571.7, орон нутгийн татварын болон татварын бус орлого 194.3, ОНХС-ийн санхүүжилт 132.2, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, өвсний авлагаас 49.9, Аймгийн Засаг даргын захирамжаар 13.5 сая төгрөгийг зарцуулах эрх нээлгэж нийт 911,8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 932,3 сая төгрөгийг зарцуулж 20.5 сая төгрөг ерөнхий орлогын дансанд үлдэгдлээр үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 932,3 сая төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 14,9 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 1,2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2.3 сая, байр ашиглахтай холбоотой зардал 0.6 сая Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгоогүйгээс 68.0, нийт 87,0 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 68.0 сая төгрөгөөр тус тус батлагдсанаас гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 49.9 сая, нийт 50.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, өвч тэжээл худалдан авахад 1.1 сая төгрөг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	208.40	194.2	14.2
Нийт орлого ба тусламжийн дүн	206.90	189.80	17.1
Татварын орлого	206.90	189.80	17.1
Орлогын албан татвар	163.40	134.80	28.6
Хувь хүний орлогын албан татвар	163.40	134.80	28.6
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	112.6	107.1	5.4

Үйл ажиллагааны орлого	14.00	7.40	6.6
Шууд бус орлого	18.80	7.63	11.17
Хөрөнгийн албан татвар	4.50	22.8	(18.3)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.40	0.56	(0.16)
Бууны албан татвар	3.65	2.97	0.68
Малын тоо толгойн албан татвар	00	19.2	(19.2)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	18.00	12.63	5.3
Бусад татвар, төлбөр, хураамж	39.51	32.25	7.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	1.88	2.96	1.1
Улсын тэмдэгтийн хураамж	0.10	0.10	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.20	0.51	(31.0)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.70	1.46	(68.54)
Газрын төлбөр	2.73	4.65	1.92
Дуудлага худалдаа	-	-	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	34.90	24.63	10.27
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	34.2	22.89	11.30
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.20	1.24	(1.03)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.50	0.59	(0.9)
Татварын бус орлого	1.60	4.47	(2.9)
Нийтлэг татварын бус орлого	1.60	4.47	(2.9)
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	1.00	3.87	2.87
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.60	0.60	-

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлогын гүйцэтгэл 194.2 сая төгрөг байгаа нь орлогын төлөвлөгөөг 14.2 сая буюу 5.7 хувиар тасалжээ. Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь Байгаль орчны яамтай гэрээ хийсэн Алтайн нүүдэлчин ТББ хуулийн хугацаанд ан агнаагүйгээс үүдэлтэй орлого тасарсан байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн татвар 0.6 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.1 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.5 сая, газрын төлбөр 1.9 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 1.0 сая төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.9 сая, торгуулийн орлого 3.9 сая төгрөгөөр тус тус орлого давж, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 6.5 сая төгрөг, хувь хүний орлогын албан тавар 11.1 сая, үйл ажиллагааны орлого 7.4 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 5.3 сая, бууны татвар 0.7 сая төгрөгөөр тус тус тасарчээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, 2021 оны төсвийн байгууллагын халаалтын дутууг Шүүхийн шийдвэрийн дагуу, аймгийн Засаг даргын 100 тоот захирамжаар 188.1 сая төгрөг, Шим –Ус ОНӨААТҮГ-аас 0.9 сая төгрөг, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 2.1, БОАЖЯ-аас хог хаягдлын үйлчилгээний хөлс 1,3 сая, статистикийн хэлтсээс 0.4 сая төгрөг, Аймгийн төрийн сангаас өр барагдуулах 8.0 сая, сумын 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 128.0 сая

төгрөг, нийт 348.7 сая төгрөгийг төвлөрүүлэн түлш халаалт, тээвэр шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 1/49 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1711.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 27.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн алдаа илэрсэнгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сумын Тамгын газрын даргын 12 удаагийн шийдвэрээр олгогдсон 12913500 төгрөгийн үр дүнгийн нэмэгдлийг мэдээлээгүй байна.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт барагдаж 67.2 сая төгрөгийн 1 албан шаардлага 101.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөгөөр/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Акт	2	0.8	2	0.8	-	-
Албан шаардлага	1	67.2	1	67.2	-	-	100.0
Зөвлөмж	4	101.3	4	101.3	-	-	100.0
Нийт дүн	7	169.3	7	169.3	-	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2015 оноос малжуулах зээл олгож байсантай холбоотой 5 иргэний зээл барагдсан байна. Үлдэгдэл 7 иргэнтэй холбоотой өрийн асуудал шүүхийн шатанд хянагдаж байна биелэлтүүдийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 128.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 113.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 12.9 төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

- ✓ ЗДТГ-т өмнөх онуудад ажиллаж байсан 2 албан хаагчтай холбоотой нийт 1480.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосныг өдий хүртэл төлүүлээгүй насажсан авлага болсон зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлаг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

- ✓ Сум байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд гарсан зардлуудаас цагаан идээ авсан талаарх 3000.0 мянган төгрөг, Улаанбаатар хотод нутгийн иргэдийг хүлээн авсан тухай 5530.0 мянган төгрөг, аж ахуйн зардал нэртэй 2000.0 мянган төгрөг, Улаанбаатар хотод иргэдтэй уулзсан гэх зардлын 6673.2 мянган төгрөгөөс баримт дутуу 1747.5 мянган төгрөг бүгд 12277.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гарах үндэслэл болно." 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын хавсралтаар "Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд боловсруулсан журнал бүртгэлийн системийн маягт, түүнийг хөтлөх зааврыг аж ахуйн нэгж, байгууллага мөрдөж ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2.1 Албан шаардлага

- ✓ Дуут сумын СХС -ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлээ хугацаандаа төлөөгүй он дамжин олон жил болж насажсан 41 иргэнтэй холбоотой 101.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн зөрчил илэрлээ. Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.1.4-д "авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар мөн зохих журмын дагуу зээлийг төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна", 3.4-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаан асуудлыг 2 тал хамтран оролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

5.3.1 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ, ИТХ-ын үйл ажиллагаанд зарцуулагдсан шатахууныг шатахууны норм баримталж тооцоо бодоогүй, зөвхөн жолоочийн тооцооны хуудсаар зарлагдсан нь нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж : Шатахууны тооцоог сар бүр машины спидометрийн заалт, шатахууны норм баримтлан бодож хэвших.

5.3.2 Шилэн данстай холбоотой

Илрүүлэлт: Сумын Тамгын газрын даргын 12 удаагийн шийдвэрээр олгогдсон 12913.5 мянган төгрөгийн үр дүнгийн нэмэгдлийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ" хуулийн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж : Шилэн дансны мэдээлбэл зохих бүх мэдээллийг нэгдсэн цэст байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая. төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	1	1.5	1	1.5				
Сум байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээтэй холбоотой	1	12.3			1	12.3		
Сум хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой	1	101.5			1	101.5		
Бараа материалтай холбоотой	1						1	
	4	115.3	1	1.5	2	113.8	1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа	1	12.9	-	-	-	-	1	12.9
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1.0	12.9					1.0	12.9

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Ц.ГАНТУЛГА